



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР  
2023 ОН**

## АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО .....	2
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ .....	2
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	3
3.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ .....	3
3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ ....	4
3.3 Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ ...	5
3.4 Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ.....	5
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ .....	5
4.1 Яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ.....	5
4.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээ .....	6
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	6
5.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ .....	6
5.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ .....	7
5.3 Шударга байдлын түвшний үнэлгээ.....	7
5.4 Хэрэглэгчийн үнэлгээ.....	7
ЗУРГАА. ДҮГНЭЛТ.....	7
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ.....	8

## ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь тус яамны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

### ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт заасан “хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, Засгийн газарт танилцуулах” гэж заасныг үндэслэл болгож хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (цаашид “журам” гэх), Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлав.

Яамны бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ журмын 6.2.1-д зааснаар зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохих хувиар илэрхийлэн үнэлсэн, харин тоо, чанараар илэрхийлэх боломжгүй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг журмын 6.2.2-т заасан аргачлалаар, байгууллагын ил тод байдал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг журмын 6.3-д заасан аргачлалаар тус тус үнэлэв.

Үйл ажиллагааны ерөнхий үнэлгээний дүнг тооцоход дараах баримт бичгийг хамруулсан. Үүнд:

#### Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт;
- салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ.

#### Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд:

- яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.

#### Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд:

- байгууллагын ил тод байдал
- шилэн дансны хөтлөлт
- шударга байдлын түвшний үнэлгээ
- хэрэглэгчийн үнэлгээ

Дээрх журмын 6.5 дахь заалт болон 6 дугаар хавсралтад заасны дагуу ерөнхий үнэлгээнд:

- бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд орсон 4 үзүүлэлт нь нийт үнэлгээний 60 хувь;
- байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд орсон 2 үзүүлэлт нь нийт үнэлгээний 20 хувь;
- байгууллагын нээлтэй байдлын үнэлгээнд орсон 4 үзүүлэлт нь нийт үнэлгээний 20 хувиар тооцсон болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус яамнаас цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн тайлангаас гадна бусад холбогдох баримт бичиг, статистик мэдээлэл дүнтэй зохих харьцуулалт хийж, 2021 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

Мөн журмын 9.6-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг ... хийх ажлыг зохион байгуулна ...”, 9.7-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшний үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно”, 9.8-д “Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу Сангийн яамны “Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2022 оны шилэн данс хөтлөлтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”, Авлигатай тэмцэх газрын “Шударга байдлын үнэлгээ” судалгааны тайлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн 2022 онд хийсэн “Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”-ны дүнг тус тус үнэлгээнд оруулан тооцов.

## ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 3.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ

Тус яамны чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, УИХ-ын болон байнгын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын шийдвэрээр үүрэгжүүлэн өгсөн 166 зүйл, заалтаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 21 хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй тул хасаж, 145 заалтын хэрэгжилтийн тайланг хянан үзэж **83.7 хувиар** үнэлэв.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ

Эрх зүйн актын төрөл	Нийт	Үнэлгээ /заалтын тоо/				Дундаж үнэлгээ /%/
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	
Монгол Улсын хууль	49	46	1	2	-	<b>96.5</b>
УИХ-ын тогтоол	27	14	10	1	2	<b>78.9</b>
УИХ-ын байнгын хорооны тогтоол	2	2	-	-	-	<b>100.0</b>
Ерөнхийлөгчийн зарлиг	8	6	-	2	-	<b>82.5</b>
Ерөнхий сайдын захирамж	2	1	1	-	-	<b>85.0</b>
ЗГ-ын тогтоол	18	7	7	2	2	<b>69.4</b>
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	36	17	13	5	1	<b>76.7</b>
ЗГ-ын албан даалгавар	2	1	1	-	-	<b>85.0</b>
ҮАБЗ-ийн зөвлөмж	1	-	1	-	-	<b>70.0</b>
<b>Нийт</b>	<b>145</b>	<b>94</b>	<b>34</b>	<b>12</b>	<b>5</b>	<b>83.7</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>	<b>100.0</b>	<b>64.8</b>	<b>23.4</b>	<b>8.3</b>	<b>3.4</b>	

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудаас хэрэгжилт хангалтгүй буюу "эрчимжүүлэх шаардлагатай" 12 заалт (www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаас харах), хэрэгжээгүй дараах 5 заалт байна. Тухайлбал:

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 8 дугаар тогтоол:**

- 1.53 дахь заалт буюу Эдийн засгийн сэргэлтийг дэмжих хөгжлийн төслийг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай анхдагч хуулийн төсөл;

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” / 2022-07-05 / 46 дугаар тогтоол:**

- 2.Үйлдвэрлэл, технологийн паркийн хууль, эрх зүйн зохицуулалт, татварын орчны талаарх танилцуулга, сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

**Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар тэмдэглэл**

- ХҮ1.10.Дорноговь аймгийн Сайншанд хотоос Ханги хилийн боомт хүртэл хатуу хучилттай авто зам тавих асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж, танилцуулах;

**Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоол**

- 2.Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулах.

### 3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 4 бодлогын 13 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хянан үзэж, **62.3 хувиар** үнэлэв.

Хүснэгт 2.Засгийн газрын үйл ажиллагааны 2022 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ /арга хэмжээний тоогоор/				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
“КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	-	1	-	-	<b>70.0</b>
Засаглалын бодлого	7	-	5	2	-	<b>67.1</b>
Нийслэл ба бус, орон нутгийн хөгжлийн бодлого	1	-	0	1	-	<b>50.0</b>
Эдийн засгийн бодлого	4	-	2	2	-	<b>55.0</b>
<b>Нийт</b>	<b>13</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>62.3</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>	<b>100.0</b>	<b>0.0</b>	<b>62.0</b>	<b>38.0</b>	<b>0.0</b>	

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5 арга хэмжээ заалт ([www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn) цахим мэдээллийн сангаас харах)-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

### 3.3 Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тус яамны хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан эдийн засгийн бодлогын хүрээний 3 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хянан үзэж, **50.0 хувиар** үнэлэв.

Хүснэгт 3. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ /арга хэмжээний тоогоор/				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Эдийн засгийн бодлого	3	0	1	2	0	<b>50.0</b>
<b>Нийт</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>50.0</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>	<b>100</b>	<b>0.0</b>	<b>33.3</b>	<b>66.6</b>	<b>0.0</b>	

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Төлөвлөгөөний биелэлтээс хэрэгжилт хангалтгүй буюу “эрчимжүүлэх шаардлагатай” 2 арга хэмжээ байна:

- 3.1.4. “Алтанбулаг” чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох;
- 3.1.9. “Замын-Үүд” чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах.

### 3.4 Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Тус яамнаас 2022 оны салбар хөгжлийн үзүүлэлтийн мэдээ, тайлан ирүүлээгүй тул **00 хувиар** үнэлэв.

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 4.1 Яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратегийн 6 зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, **77.1 хувиар** үнэлэв.

Хүснэгт 4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

№	Чиг үүрэг	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээ /арга хэмжээний тоогоор/				Дундаж үнэлгээ /%/
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
1	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ	2	18	4	13	0	1	78.3
2	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	22	74	29	26	16	3	76.8
	<b>Нийт</b>	<b>24</b>	<b>92</b>	<b>33</b>	<b>39</b>	<b>16</b>	<b>4</b>	<b>77.1</b>
	<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>			<b>35.9</b>	<b>42.4</b>	<b>17.4</b>	<b>4.3</b>	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Төлөвлөгөөний биелэлтээс хэрэгжилт хангалтгүй буюу "эрчимжүүлэх шаардлагатай" 16 арга хэмжээ (www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаас харах), хэрэгжээгүй 4 арга хэмжээ (3.2.1, 3.16.5, 3.21.4, 4.1.3) байна.

## 4.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээ

Тус яамны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, **77.1 хувиар** үнэлэв.

Хүснэгт 5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Зорилт	Үйл ажиллагаа	Үнэлгээ /%/
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	1.Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	<b>90.0</b>
	2.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	<b>70.0</b>
	3.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	<b>50.0</b>
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	4.Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	<b>100.0</b>
	5.Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	<b>70.0</b>
	6.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	<b>90.0</b>
	7.Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	<b>70.0</b>
<b>Дундаж үнэлгээ /%/</b>		<b>77.1</b>


Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

## ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

### 5.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийн ил тод байдлын дундаж үнэлгээ **58.7 хувьтай** байна.

График 1. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ /хувиар/



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Цахим хуудас болон мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлбэл зохиох 46 нээлттэй мэдээллээс 3 мэдээлэл “бүрэн” буюу 100 хувь, 20 мэдээлэл “хэрэгжих шатанд” буюу 70 хувь, 2 мэдээлэл “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувь байна. Тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй болон хугацаа болоогүй шалтгаанаар 16 мэдээллийг үнэлээгүй болно.

Үнэлгээний дүнгээс харахад, тус яам нь хүний нөөц, төсөв санхүүгийн талаарх мэдээллийг бусад төрлийн мэдээллээс илүү “ил тод” мэдээлдэг бол чиг үүрэг, үзүүлж байгаа үйлчилгээ, бусад мэдээллийн ангилалд багтах мэдээллийг “хангалтгүй” мэдээлж байна. Тухайлбал:Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээллүүд гэх мэт.

## 5.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Сангийн яамны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны шилэн данс хөтлөлтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нэг байгууллага 138 удаа мэдээлэл байршуулахаас 133 удаа мэдээллийг байршуулж, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ **95.9 хувь** байна.

Хүснэгт 6. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Төсвийн ерөнхийлөн захирагч		Эдийн засаг, хөгжлийн сайд
Харьяа байгууллагын тоо		1
Нэг байгууллага дунджаар мэдээлэл байршуулах давтамжийн тоо	байршуулах	138
	байршуулсан	133
Хугацаанд нь мэдээлэл байршуулсан байдал	хугацаанд нь байршуулсан	128
	хугацаа хоцроосон	5
<b>Үнэлгээ, %/</b>		<b>95.9</b>

Эх сурвалж: Сангийн яам

## 5.3 Шударга байдлын түвшний үнэлгээ

Авлигатай тэмцэх газрын 2022 оны шударга байдлын үнэлгээгээр Эдийн засаг, хөгжлийн яам нь **79.4 хувь**, улсын дунджаас 5.5 нэгж хувиар илүү үнэлэгдсэн байна.

## 5.4 Хэрэглэгчийн үнэлгээ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээр хийлгэсэн "Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн 2022 оны судалгаа"-ны тайланд тус яамны үйл ажиллагааны салбарын иргэдийн сэтгэл ханамж үнэлэгдээгүй тул хэрэглэгчийн үнэлгээг судалгаанд хамрагдсан 16 салбарын дундаж **62.4 хувиар** тооцож ерөнхий үнэлгээнд ашиглав.

## ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 49.0 хувь, чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 77.10 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 74.1 хувь, ерөнхий үнэлгээ **59.64 хувиар** үнэлэгдсэн байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Ерөнхий үнэлгээ

№	Үзүүлэлт		Дундаж үнэлгээ %/
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	83.70
		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	62.31
		Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	50.00
		Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	0.00
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	77.10
		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	77.10
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын ил тод байдал	58.70
		Шилэн дансны хөтлөлт	95.90
		Шударга байдлын үнэлгээ	79.40
		Хэрэглэгчийн үнэлгээ	62.40



Оноо	2.98
Ерөнхий үнэлгээ	59.64

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй 17 зүйл заалт, Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний эрчимжүүлэх шаардлагатай 5 заалт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн "эрчимжүүлэх шаардлагатай" болон "үр дүнгүй" гэж үнэлэгдсэн 20 арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, ажлын удирдлага, зохион байгуулалт, сахилга хариуцлагыг дээшлүүлж, 2023 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжилтийг ханган ажиллах нь зүйтэй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв бодит мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгох чиглэлээр хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажил хангалтгүй байна.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Тус яамны 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

### **Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:**

1.Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хүрээнд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, үе шат, хэрэгжих хугацаа, гарах үр дүн, өмнөх жилийн гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудал зэргийг нарийвчлан судалж, судалгааны үр дүнг төлөвлөлтөд ашиглаж хэвших;

2.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг боловсруулахдаа эдийн засаг, нийгмийн төлөв байдлын талаарх албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлого, онцлогтой уялдуулан төлөвлөж байх;

3.Хөгжлийн бодлогын зорилго, зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжихүйц байхаар тодорхойлох;

4.Төсвийн төлөвлөлтийн хүрээнд бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг үндэслэл, тооцоо, судалгаанд тулгуурлан бодитой төлөвлөх;

5.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу бодлогын баримт бичиг болон салбарын стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодитой, биелэгдэхүйц, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцох зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж гүйцэтгэлийн тайлан нь иж бүрэн, алдаа мадаггүй, илтгэл үнэмшил төрүүлэхүйц үр дүнд суурилсан байх.

**Бодлогын баримт бичгийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагналтыг сайжруулах талаар:**

1.Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, тухайн жилийн хүрэх түвшинг бүрэн хангах;

2.Бодлогын баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тухай бүр хамтран шийдвэрлэж байх;

3.Бодлогын баримт бичиг болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихүйц урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр зорилтот түвшинд хүрсэн үр дүн, үр нөлөөг илэрхийлэхүйц байдлаар тайлагнах;

4.Хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn) мэдээллийн цахим системд оруулахдаа хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнах;

5.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа зорилт арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган холбогдох мэдээллийг хавсаргаж байх;

6.Хууль тогтоомж, бодлого шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, 2023 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжүүлэх.

**Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:**

1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, олон нийтийг нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангасан байх;

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах;

3.Байгууллагын цахим хуудсыг “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандартын дагуу хөтөлж, хэвшүүлэх.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, үр нөлөөг сайжруулах талаар:**

1.Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үйл явцад хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

2.Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшин, хүрсэн үр дүнг үндэслэн үнэн зөв, бодитой үнэлэх;

3.Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоотойгоор хөндлөнгийн үнэлгээ хийж, яамны удирдлага болон холбогдох нэгжүүдэд дүгнэлт, зөвлөмж хүргүүлж, хамтран ажиллах зэрэг болно.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР